



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/420

Арвайхээр

**Аймгийн 2021-2022 оны цэрэг татлагын
товчоо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн хэмжээнд 2021-2022 оны цэргийн жинхэнэ албаны халалт, татлагыг удирдан зохион байгуулж ажиллах “Цэрэг татлагын товчоо”-ны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Аймгийн цэрэг татлагын товчооны дарга, орлогч даргад **ДААЛГАХ** нь:

а)Цэрэг татлагын товчооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоож, цэрэг татлагын ажилтай холбоотой хууль, эрх зүйн баримт бичиг, тухайн ажлыг гүйцэтгэх онцлогийн талаар зааварчилгаа өгч, бусад зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

б)Цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг сайтар зохион байгуулж, “Цэргийн гэрээт алба хаах журам”-ын дагуу цэргийн гэрээт албанд элсүүлэх, “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг баримтлан иргэдийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн татаж, Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн хяналтын тоог биелүүлэх;

в)Цэрэг халалт, татлагын ажлын явцад байнгын хяналт тавьж, цэрэг татлагын товчооны үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг цаг тухайд нь хуулийн дагуу шийдвэрлэж ажиллах;

г)Засгийн газрын 2018 оны 11 дүгээр тогтоол “Цэргийн гэрээт алба хаах журам”, 2018 оны 80 дугаар тогтоол “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын талаар сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, түүнд иргэдийг элсүүлэх ажлыг зохион байгуулах;

д)Цэрэг татлагын ажлын дүн мэдээг 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин Штабт өгөх;

е)2021 оны 11 дүгээр сард 2021 оны цэрэг татлагыг зохион байгуулж явуулсан дүнгийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын талаар хэлэлцүүлж цаашид авах арга хэмжээг тодорхойлох;

011100895

2.

3.Цэрэг татлагын товчооны гишүүдэд ДААЛГАХ нь:

а)Цэрэгт татагдагчдад эрүүл мэндийн үзлэг явуулах нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг томилон холбогдох зааварчилгааг өгч, шаардлагатай байр, эм эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун)-д;

б)Цэрэг халалт, татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг сахиж, цэрэг татлагын байранд мэргэжлийн байгууллагаар өдөрт 2-с доошгүй удаа ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж, эрүүл мэндийн газраас мэргэжлийн албан тушаалтан томилж хяналт тавин, аймгийн онцгой комиссын шийдвэрийг чанд мөрдөн хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т;

в)Аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу цэргээс халагдан ирж байгаа дайчдыг ирэх замд нь тосож, Коронавируст халдвар (ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон ар гэрт нь нь хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб (хурандаа М.Дэлгэрсайхан), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-т;

г)Сумдад цэрэг халалт, татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зарлан дуудах хуудас авсан боловч тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд ирээгүй цэргийн үүрэгтнийг эрэн сурвалжилж татлагаар оруулах бүх талын арга хэмжээ авахыг аймгийнЦагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ)-т;

д)Цэрэгт татагдагчдыг тээвэрлэх автомашины техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулж зөвшөөрөл өгөх, жолооч нарын хариуцлагыг дээшлүүлж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг (цагдаагийн хошууч Б.Алтан-Эрдэнэ)-т;

е)Цэргийн жинхэнэ алба хааж бэлтгэлээр халагдаж ирсэн цэргийн үүрэгтнүүдийг бүртгэж, ажлын байрны мэдээллээр хангаж, төрөл бүрийн сургалтад хамруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Т.Нарангарав)-т тус тус даалгасугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дугаар сарын 07-ны өдрийн 11420 дугаар захирамжийн хавсралт



**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2021-2022 ОНЫ ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ
ХАЛАЛТ, ТАТЛАГЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАХ
“ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧОО”-НЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Ц.Ганболд -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Орлогч дарга: М.Дэлгэрсайхан -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын дарга, хурандаа

Нарийн бичгийн дарга: Ч.Ванчинсүрэн -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, хошууч

Гишүүдэд: А.Отгонцэцэг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн дарга

Ц.Идэрсайхан -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч

Б.Мөнх-Эрдэнэ -Аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

Ж.Пүрэвсүрэн -Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн
газрын дарга

Т.Нарангарав -Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын дарга

Д.Шиваанүрдэв -Аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга

Ж.Уламбаяр -Тагнуулын ерөнхий газрын Өвөрхангай аймаг дахь хэлтсийн
дарга, хурандаа

Д.Одонбаяр -Аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа

Э.Хүдэрчулуун -Аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга

Б.Сүхбаатар -Аймгийн Зооноз өвчин судлалын төвийн дарга